



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А160

Сангийндалай

Эд хөрөнгийн үзлэг тооллого  
явуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 09 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 64 дүгээр тогтоол, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалт, 72 дугаар зүйлийн 72.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын эзэмшилд байгаа эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдал, хэмжээг тогтоох, дутагдуулсан, бүртгэлгүй орхигдуулсан ашиглагдахгүй байгаа хөрөнгийг тоолон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Б.Өнөрбилэг (Хүний нөөц, хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан)

Гишүүдэд: И.Дүрзээ (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Т.Энхбат (Тусгай сан хариуцсан нягтлан бодогч)

Д.Батбаяр (Байгаль орчны Улсын байцаагч)

Ж.Нэргүй (Засаг даргын Тамгын газрын үйлчлэгч)

2. Тооллогыг 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс 12 дугаар сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд нүд үзэн, акт үйлдэн чанартай гүйцэтгэхийг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА



ЭНХДЭЛГЭР